



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН АЛБАН ЁСНЫ
БОЛОН ЗАХИРГААНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН
ТАНИЛЦУУЛГА - 2017



УЛААНБААТАР ХОТ

2018 ОН



ДОТООД ХУДАЛДАА

Дүүргийн албан ёсны болон захиргааны статистик мэдээгээр 2017 онд худалдааны салбараар 723 аж ахуй нэгж, байгууллага түүврээр ирж, өмнөх оныхоос 151 аж ахуй нэгж, байгууллага буюу 1.7 хувиар нэмэгдсэн байна.

ДҮҮРГИЙН ХУДАЛДААНЫ САЛБАР, тоогоор

Үзүүлэлт		2013	2014	2015	2016	2017
Дүүрэг	Аж ахуйн нэгж, байгууллагын тоо	578	974	887	572	723
	Ажиллагчдын тоо	5884	8422	8120	9967	11371




Худалдааны нийт борлуулалтад тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалтыг оруулах бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно.

ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТ, дүүрэг, сая.төг

Худалдааны нийт борлуулалтад тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалтыг оруулах бөгөөд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно.

БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА, дүүрэг, сая.төг



Албан ёсны статистик мэдээллээр бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт 2017 онд 1519.7 тэр бум төгрөг болж, өмнөх оныхоос 484.2 сая төгрөг буюу 1.5 хувиар өссөн байна. Нийт борлуулалтын 46.3 хувийг жижиглэн, 53.3 хувийг бөөний худалдаа тус тус эзэлж байна.


ХУДАЛДААНЫ НЭГ ЦЭГТ НОГДОХ ХҮНИЙ ТОО, дүүрэг

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017
	Тоо				
Дүүрэг	243	249	260	272	227

$$\text{Худалдааны нэг цэгт ногдох хүний тоо} = \frac{\text{Суурин хүн амын жилийн дундаж тоо}}{\text{Нийт цэгийн тоо}}$$

Худалдааны нэг цэгт ногдох хүний тоог тайлант хугацааны суурин хүн амын жилийн дундаж тоог тухайн хугацааны худалдааны салбарын нийт цэгийн тоонд харьцуулж тодорхойлно

ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН ТОО, дүүрэг



Албан ёсны болон захиргааны статистик мэдээллээр 2017 онд хүнсний дэлгүүр 981, бөөний болон худалдааны төв 70, түргэн үйлчилгээний цэг 212, гутал болон авто засвар үйлчилгээ 199 аж ахуйн нэгж байгууллага жилийн турш үйл ажиллагаа явуулсан байна.

ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН ТОО, дүүрэг

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017
Бөөний болон худалдааны төв	53	59	48	48	70
ТҮЦ	100	97	82	82	212
Дэлгүүр	907	904	898	898	981
Гутал, болон авто засвар	173	172	182	161	199

Худалдааны нийт цэгийн тоонд тайлант хугацаанд бизнес регистрийн санд бүртгэлтэй худалдааны салбарын аж ахуйн нэгжийн тоо, албан бус секторт хамрагдах цэг /чингэлэг, түргэн үйлчилгээний цэг, лангуу, гутал засвар, авто засварын газар зэрэг/-үүдийг хамруулна.




ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАР

Зочид буудлын салбарын нийт үйлдвэрлэл дүүргийн албан ёсны статистик мэдээллээр 2017 онд 29.3 сая төгрөг болж, өмнөх оныхоос 8.2 сая төгрөг буюу 1.3 хувиар буурч, нийтийн хоолны салбарын нийт үйлдвэрлэл 33.0 сая төгрөг болж өмнөх оныхоос 1.9 сая төгрөг буюу 0.9 хувиар өсөв.


ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ дүүрэг, сая.төг

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017
Бүгд	40.4	51.8	58.2	68.6	62.3
Зочид буудал	30.7	28.2	38.9	37.5	29.3
Нийтийн хоол	9.7	23.6	19.3	31.1	33.0



Зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн тайлангаар ажиллагчдын тоо, бараа, бүтээгдэхүүний борлуулалт, зардал, үндсэн хөрөнгө болон санхүүгийн үзүүлэлтүүдийг нэгтгэн гаргаж байна.

ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД, дүүрэг, тоогоор



Зочид буудлын үйл ажиллагаанд амралтын газар, хүүхдийн зуслан, түр хоноглох байруудыг хамруулна. Зоогийн газрын үйл ажиллагаанд ресторан, кафе, баар, гуанз, цайны газар, катеринг, тусгай захиалгат хоол хүнсээр үйлчлэх газруудыг хамруулна. Албан ёсны статистик мэдээллээр 2017 онд 2405 ажиллагчид байсан ба

үүнээс зочид буудалд 1179, нийтийн хоолны салбарт 1226 ажиллагчид болж, өмнөх оныхоос зочид буудалд 360 хүн буюу 1.4 хувиар, нийтийн хоолны салбарт 152 хүн буюу 0.8 хувиар ажиллагчдын тоо нэмэгдсэн байна.



СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ НЭТ ДОРООС...

www.1212.mn



Apple store-оос татаж авна уу

Нэгтгэн боловсруулсан мэргэжилтэн:

Хянасан хэлтсийн дарга:



П. Мөнхцэцэг

Э. Энхтунгалаг

Цахим хаяг: www.nso.mn
www.1212.mn
www.ubstat.mn

E-mail: Bayanzurkh@nso.mn

Утас: 267349, 261019